

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/06

Арвайхээр

Ажлын хэсэг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66.3, 66.5, Төрийн өмчийн хорооны 2010 оны 166 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмч эзэмшүүлэх гэрээ дүгнэх журмыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Орон нутгийн өмчит ХК, ХХК, ААТҮГ-ын гүйцэтгэх захирлын аймгийн Засаг даргатай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээ, өмч эзэмшүүлэх гэрээ, санхүү эдийн засгийн үйл ажиллагааг хянан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: М.Нинжбадгар/Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн/

Гишүүд: Г.Ариунаа / Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн /

Б.Дэлгэрмаа/ Орон нутгийн өмчийн газрын санхүү, өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн/

А.Баяндүүрэн /Орон нутгийн өмчийн газрын хууль эрх зүй, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн мэдээлэл лавлагаа, хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн

програм хариуцсан мэргэжилтэн/

Т.Гантулга /Орон нутгийн өмчийн газрын ажил худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн/

2. Шалгалтын ажлын хуваарийг баталж, шалгалтын үйл ажиллагааг хуваарийн дагуу явуулан дүн мэдээг нэгтгэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /М.Нинжбадгар/-т даалгасугай.

ДАРГА



Н.ГАНБОЛД

177110011